



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2016 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/69

Улаанбаатар хот

Төвийн шуурхай удирдлагын нэгжийн  
ажиллах журмыг шинэчлэн батлах тухай

Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх Ази, Номхон далайн бүсийн стратеги (APSED-2010), ДЭМБ-ын үйл явдалд суурилсан тандалтын тогтолцоог бэхжүүлэх" гарын авлага, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 355 дугаар тушаал "Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал, хариу арга хэмжээг сайжруулах зарим арга хэмжээний тухай" тушаалын заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Төвийн шуурхай удирдлагын нэгжийн ажиллах журмыг I, хөтлөгдөх анхан шатны бүртгэл маягт (хүснэгт 1, 2, 3, 4, 5, 6)-ыг II, Төвийн шуурхай удирдлагын нэгжийн багийн бүрэлдэхүүнийг III, Эрсдлийн түргэвчилсэн үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүнийг IV хавсралтаар тус тус баталсугай.
2. Төвийн шуурхай удирдлагын нэгжийн ажиллах журмыг мөрдлөг болгон ажиллахыг Мэргэжлийн тусламжийн алба /Д.Ганболд/-нд үүрэг болгосугай.
3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, хүний нөөц, статистикийн алба /Д.Цэрэнноров/-нд даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан ЗӨСҮТ-ийн захирлын 2012 оны 04-р сарын 05-ны өдрийн А/38, 2016 оны 01-р сарын 08-ны өдрийн А/01 дүгээр тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Н.ЦОГБАДРАХ

10  
10  
2016  
Төвийн захирлын ..... оны  
..... дугаар сарын 06 ны өдрийн  
Агс дугаар тушаалын I хавсралт

## ШУУРХАЙ УДИРДЛАГЫН НЭГЖИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Зоонозын шалтгаант үйл явдлын мэдээг цуглуулах, эрсдлийн үнэлгээ хийх, орон нутгийн болон хамтран ажилладаг байгууллагууд, шийдвэр гаргагчдыг бодит мэдээллээр тогтмол хангах, бэлэн байдлыг хангах, эрсдлийн үеийн харилцаа холбоог хэрэгжүүлэх, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээг мэргэжлийн багийн оролцоотойгоор шуурхай зохион байгуулах зорилго бүхий Шуурхай удирдлагын нэгж (цаашид ШУН гэх) ажиллана.
- 1.2. ШУН нь үйл ажиллагаандаа Олон улсын эрүүл мэндийн дүрэм, “Шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнүүдтэй тэмцэх, сэргийлэх Ази номхон далайн стратеги” 2010-2015, “Эрүүл мэндийн тухай” хуулийн 11, 12, 35 дугаар зүйл, “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 27 дугаар зүйлийн 27.1.9 дэх заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 355 дугаар тушаал зэрэг эрх зүйн баримт бичгүүд, зоонозын өвчний чиглэлээр баримталж буй тушаал, журам, стандартын холбогдох заалтуудыг баримтална.
- 1.3. ШУН нь Төвийн захирлын шууд удирдлагад ажиллана.
- 1.4. ШУН нь хэвийн үйл ажиллагаа явуулах орчин, дэд бүтэц, аюулгүй байдлыг хангасан байртай байна.
- 1.5. Зоонозын халдварт өвчний үйл явдалд болон тохиолдолд суурилсан тандалтын тогтолцооны дагуу албан болон албан бус сувгаар мэдээлэгдсэн үйл явдлыг эрт илрүүлэх, нягтлан баталгаажуулах, эрсдлийн үнэлгээ хийх, эрсдлийн үнэлгээнд тохирсон хариу арга хэмжээг зохион байгуулах, эргэн мэдээлэх үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдөнө.
- 1.6. Батлагдсан журмыг ЗӨСҮТ, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин судлалын төвүүд мөрдөн хэрэгжүүлнэ.

### Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

- 2.1. Зоонозын шалтгаант үйл явдал гэдэг нь: Хүн ам, байгууллага, хамт олон, гэр бүлийн дунд гарсан зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлууд,

- мал, амьтан, дамжуулагч үе хөлтөн шавж, мэрэгчдээс шалтгаалсан хүн амын өвчлөл гарсан гэх цуурхал, дам яриа, мал, амьтан, дамжуулагч, шавж мэрэгчдийн өвчлөл, үхэл хорогдол, хэвийн бус өвчлөлийн байдал, шинэ, ховор тохиолдлуудыг;
- 2.2. Зоонозын шалтгаант үйл явдалд суурилсан тандалт гэдэг нь: Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал үүсгэж болзошгүй зоонозын шалтгаант эрсдэлт зүйлсийн тухай мэдээг эрт цуглуулан, нягтлан баталгаажуулж, эрсдлийг үнэлэх, эрсдлийн үнэлгээнд тохирсон хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, мэдээлэх, эргэн мэдээлэх үйл ажиллагааг;
  - 2.3. Тохиолдолд суурилсан тандалт гэдэг нь: тохиолдлын тодорхойлолтод тохирсон зоонозын халдварт өвчний хам шинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх, мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах, эргэн мэдээлэх өвчлөлийн босго үзүүлэлтийг хянах тандалтын тогтолцоог;
  - 2.4. Тохиолдлын удирдлагын тогтолцоо гэдэг нь нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн хариу арга хэмжээг эрсдлийн төрөл, түвшингээс үл хамааран шуурхай нэгдсэн зохион байгуулалттайгаар удирдах, хянах, зохицуулах, хүний нөөц, хууль, журам, стандарт, зориулалтын байр дэд бүтэц бүхий шаталсан удирдлагын цогц бүтцийг;
  - 2.5. Эпидемиологийн долоо хоног гэдэг нь Ням гарагаас Бямба гараг хүртэлх долоо хоногийн хугацааг хэлнэ.

### **Гурав. Удирдлага, бүтэц, зохион байгуулалт**

- 3.1. ШУН нь зоонозын халдварт өвчний үед зохион байгуулагчийн үүрэгтэйгээр байнгын бэлэн байдалд байна.
- 3.2. ШУН нь тайван цагийн болон идэвхжсэн үеийн гэсэн үйл ажиллагааны үндсэн хоёр горимтой байна.
- 3.3. Тайван цагийн горимын үед дарга, менежер, зохицуулагч, үйл явдалд суурилсан тандалт хариуцсан эмч, мэдээллийн ажилтан, эрсдлийн харилцаа холбоо хариуцсан мэргэжилтнээс бүрдсэн баг (Цаашид баг гэх...) ажиллана.
- 3.4. ШУН-ийн байрыг ШУН-ийн үндсэн чиг үүргээс гадна дараах зориулалтаар менежер зохицуулагч нарын зөвшөөрлөөр ашиглаж болно.
  - 3.4.1. Орон нутгийн мэргэжлийн байгууллагууд оролцсон цахим хурал;
  - 3.4.2. 10-15 хүний бүрэлдэхүүнтэй богино хугацааны сургалт, хурал, уулзалт;

- 3.4.3. Төвийн захиргааны зөвлөлийн хурал болон байнгын үйл ажиллагаа бүхий хороо, зөвлөлүүдийн хурал;
- 3.4.4. Цаг үеийн асуудлаар ЭМЯ, бусад эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудтай хийх шуурхай цахим хурал;
- 3.4.5. Олон улсын байгууллагын зөвлөхүүдийн уулзалт, сургалт зохион байгуулах;
- 3.5. Зоонозын халдварт өвчний дэгдэлт гарах, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал үүсэх магадалтай эсвэл үүссэн тохиолдолд эрсдлийн түргэвчилсэн үнэлгээний дүнгээр өндөр маш өндөр үнэдлэгдсэн тохиолдолд ШУН идэвхжлийн горимд шилжиж тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллана.
- 3.6. Идэвхжсэн үеийн горимд шилжсэн тохиолдолд Төвийн захирал (*ШУН-ийн менежер орлон ажиллана.*)-ын шууд удирдлага дор Тохиолдлын удирдлагын тогтолцоо (ТУТ) ажиллаж эхэлнэ.
- 3.7. ШУН нь цахим хуудас, тусгайлсан цахим шуудангийн хаяг, суурин ба хөдөлгөөнт холбооны утас, фейсбүүк хуудастай байна.

#### **Дөрөв. Үйл ажиллагааны үндсэн чиглэл**

ШУН нь тайван цагийн ба идэвхжлийн горимуудаар үйл ажиллагаагаа зохион байгуулж явуулна.

#### **4.1. ШУН-ийн тайван цагийн горимын үйл ажиллагаа:**

- 4.1.2. ШУН-ийн өдөр тутмын үйл ажиллагаа нь тайван цагийн горимд хамаарна.
- 4.1.3. Зоонозын халдварын хүн, малын сэжигтэй тохиолдол, өвчлөл, зоонозын шалтгаант үйл явдлын мэдээнд дүн шинжилгээ хийж, мэдээллийг нэгтгэж ШУА болон төвийн удирдлага, аймаг нийслэлийн ЗӨСТ, ЭМГ-уудад өдөр бүр цахим хаягаар хүргүүлэх;
- 4.1.4. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал, зоонозын халдварт өвчний дэгдэлт, цар тахлын үеийн бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол, нэмэлт хийх санал оруулах; аймаг, нийслэлийн ЗӨСТ-үүдийн үйл ажиллагааг уялдуулан чиглүүлэх, хянах;
- 4.1.5. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал үүсгэж болзошгүй үйл явдлыг цуглуулах, тандах, баталгаажуулах;
- 4.1.6. Зоонозын халдварын бүртгэгдсэн тохиолдол, үйл явдлыг баталгаажуулж, эрсдлийн түргэвчилсэн үнэлгээг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу хийж, ШУА-д 24 цагийн дотор мэдээлэх;

- 4.1.7. Нийгмийн эрүүл мэндийн онцгой үйл явдлын бэлэн байдлыг хангахтай холбоотой онолын болон дадлагажуулах сургалтуудыг ЗӨСҮТ-ийн мэргэжилтнүүд, аймаг нийслэлийн ЭМГ, ЗӨСТ-ийн мэргэжилтнүүдэд зохион байгуулах;
- 4.1.8. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын хариу арга хэмжээнд эргэмж үнэлгээ хийх, төлөвлөгөөнд тодотгол хийх;
- 4.1.9. Хүн амд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааны материал бэлтгэн сурталчлах, эрсдлийн үеийн харилцаа холбооны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

#### **4.2. Идэвхжлийн горимд шилжсэн үеийн үйл ажиллагаа:**

- 4.2.1. Энэхүү журмын 3.5-д заасан нөхцөл байдал үүссэн үед төвийн захирлын шийдвэрээр идэвхжлийн горимд шилжинэ.
- 4.2.2. ШУН нь өдөр тутмын хурлыг ШУН-д ажиллах баг, сарын дуудлага хариуцсан тархвар судлагч, лабораторийн эмч, эмнэлзүйч эмчийн оролцоотойгоор зоонозын халдварын хүний өвчлөл, үйл явдал бүртгэгдсэн тохиолдолд 9:00 цагт зохион байгуулна.
- 4.2.3. Идэвхжлийн горимоор ажиллах цагийн хуваарь “уртасгасан цагаар” байж болно.
- 4.2.4. Идэвхжлийн горимоор ажиллах цагийн хуваарийн төрлийг үүссэн нөхцөл байдлыг харгалзан Төвийн захирал тогтооно.
- 4.2.5. Зоонозын халдварт өвчний дэгдэлт, үйл явдал бүртгэгдсэн болон байнгын бүртгэгддэг өвчлөл хэвийн босго үзүүлэлтээс давсан, нийгмийн эрүүл мэндэд онцгой байдал үүсгэж болзошгүй шалтгаан тодорхойгүй, гэнэтийн шинжтэй өвчлөл, зоонозын шалтгаант хүн, мал, амьтны зүй бус хорогдол зэрэг тохиолдлуудад хариуцсан мэргэжлийн багтай хамтран эрсдлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээг зохион байгуулан ажиллах;
- 4.2.6. Эрсдлийн түргэвчилсэн үнэлгээ хийж хариу арга хэмжээг зохион байгуулах багийн бүрэлдэхүүнийг эрсдлийн төрлөөс хамааран халдвар хариуцсан мэргэжлийн баг, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан томилгоот багийг дайчлан ажиллуулна.
- 4.2.7. Бүртгэгдсэн үйл явдлыг баталгаажуулан, эрсдлийн түргэвчилсэн үнэлгээг халдвар хариуцсан мэргэжлийн багийг оролцуулан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмыг баримтлан ажиллана.
- 4.2.8. Идэвхжлийн горимд ажиллах дотоод нөөц бололцоо хүрэлцэхгүй болсон тохиолдолд ТУТ-д шилжих саналыг ШУН-ийн баг төвийн захиралд тавина.

### **Тав. ШУН-ийн өдөр тутмын мэдээ солилцох үйл ажиллагаа**

- 5.1. ШУН нь долоо хоног бүрийн Баасан гарагийн 9:00 цагт ЭМЯ-ны ШУА, ХӨСҮТ, НЭМХ-ийн мэдээлэл солилцох хуралд цахимаар оролцож, тухайн долоо хоногт олон улсын болон Монгол улсад бүртгэгдсэн зоонозын халдварт өвчин, үйл явдлын талаарх товч мэдээллийг Power point хэлбэрээр бэлтгэж танилцуулна.
- 5.2. Баасан гарагийн Шуурхай хуралд оролцож мэдээлэл солилцох орон тооны бус гишүүдийг хавсралтаар батална.
- 5.3. **ШУН-нь дараах эрүүл мэндийн байгууллагуудтай мэдээлэл солилцож ажиллана.** Үүнд:
  - 5.3.1. Орон нутаг дахь Зоонозын өвчин судлалын төв
  - 5.3.2. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар
  - 5.3.3. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн
  - 5.3.4. Халдварт өвчин судлалын үндэсний төв
  - 5.3.5. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд
- 5.4. **ШУН нь бусад салбарын дараах байгууллагуудтай мэдээлэл солилцож ажиллана.** Үүнд:
  - 5.4.1. Онцгой байдлын ерөнхий газар
  - 5.4.2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
  - 5.4.3. Мал эмнэлэг, үржлийн газар
  - 5.4.4. Мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
  - 5.4.5. Мал эмнэлгийн хүрээлэн
- 5.5. ШУН-ийн өдөр тутмын мэдээг маягтын дагуу бэлтгэн ЭМЯ-ШУА, төвийн удирдлагууд, халдвар хариуцсан багийн ахлагч, мэдээлэл солилцон ажилладаг бусад байгууллагуудад цахим хэлбэрээр хүргүүлнэ.
- 5.6. Өдөр тутмын шинэчлэгдсэн мэдээллээр төвийн цахим хуудас, фейсбүүк хуудсыг тогтмол баяжуулна.

### **Зургаа. ШУН-ийн ажиллах багийн чиг үүрэг**

- 6.1. **ШУН-ийн менежер дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**
  - 6.1.1. Шаардлагатай үед шуурхай хурлыг удирдан зохион байгуулж, шийдвэр гаргах;
  - 6.1.2. ШУН-д ажиллах багийн бүрэлдэхүүнийг өдөр тутмын мэргэжил аргагүйн удирдлагаар хангах;
  - 6.1.3. Өдөр тутмын шинэчлэгдсэн мэдээ болон сурталчилгааны материалыг хянах;

6.1.4. ШУН-ийн үйл ажиллагааг холбогдох бусад байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах;

6.1.5. ШУН-ийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, тайлан хүлээж авч баталгаажуулах;

## **6.2. Үйл явдалд суурилсан тандалт хариуцсан тархвар судлагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

6.2.1. Үйл явдлын мэдээнд тандалт хийх, олон улсын болон дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсын жагсаалт гаргах, тогтмол шинэчлэх;

6.2.2. Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээс зоонозын шалтгаант үйл явдлын мэдээг өдөр бүр түүвэрлэх;

6.2.3. Тухайн бүртгэгдсэн сэжигтэй тохиолдол, үйл явдалтай холбоотой мэдээллийг баталгаажуулах бусад байгууллагад хүргүүлэх;

6.2.4. Бүртгэгдсэн сэжигтэй тохиолдол, үйл явдалтай холбоотой хэвлэлийн мэдээ бэлтгэх;

6.2.5. Бүртгэгдсэн үйл явдал, зонхилон тохиолдож буй халдварт өвчнүүдийн тоон мэдээнд дүн шинжилгээ хийх, босго үзүүлэлт тооцох, үйл явдлын хандлагыг тодорхойлох;

6.2.6. Үйл явдалд суурилсан тандалтын үйл ажиллагааг олон нийтэд болон эрүүл мэндийн байгууллагуудад сурталчилах;

6.2.7. Бүртгэгдсэн үйл явдлын мэдээний эх сурвалжийн жагсаалтыг хөтлөх;

6.2.8. Бүртгэгдсэн үйл явдлын мэдээний сан үүсгэж, дүн шинжилгээ хийж, архивлах;

6.2.9. Орон тооны бус гишүүдийн хурлын ирцийг бүртгэх, хугацаат үүрэг даалгаврын биелэлтийг хянах;

6.2.10. ШУН-ийн бусад дотоод үйл ажиллагаанд оролцох.

## **6.3. ШУН-ийн зохицуулагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

6.3.1. ШУН-ийн үйл ажиллагааг төвийн удирдлагууд, орон нутгийн ЗӨСТ, ЭМГ-ууд, олон улсын болон салбар хоорондын хамтын ажиллагааны байгууллагуудтай уялдуулан зохион байгуулах;

6.3.2. Зоонозын халдварт өвчний дэгдэлт, үйл явдал бүртгэгдсэн тохиолдолд халдвар хариуцсан багийн гишүүдийг цуглуулж, түргэвчилсэн эрсдлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээг зохион байгуулах;

6.3.3. Орон нутгийн ШУН, ЗӨСТ, ЭМГ-уудын тандалтын мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах;

- 6.3.4. Эрсдлийн үеийн харилцаа холбооны багтай хамтран ажиллах, зоонозын халдварт өвчний талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийх;
- 6.3.5. Орон тооны болон орон тооны бус гишүүдийн бүрэлдэхүүнд зориулсан тасралтгүй сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх;
- 6.3.6. Баталгаажуулсан үйл явдалд эрсдлийн түргэвчилсэн үнэлгээний багийн хийсэн үнэлгээний тайланг хамтран гаргах, хянах;
- 6.3.7. Үйл явдалтай холбоотой албан мэдээллүүдийг холбогдох тасаг, нэгжээс гаргуулан авах;
- 6.3.8. Хариу арга хэмжээний багийн нөөцийн бэлэн байдлыг хангах, зарцуулалтад хяналт тавих;
- 6.3.9. ШУН-ийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг архивлах;
- 6.3.10. ШУН-ээс гаргасан бүх төрлийн мэдээллүүдийг хянах.

**6.4. Мэдээ, мэдээлэл, эрсдлийн үеийн харилцаа холбооны мэргэжилтэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

- 6.4.1. Тэргүүлэх чиглэлд багтсан үйл явдлын талаар хүн амд зориулсан мэдээлэл, сурталчилгааны материалыг инфографик хэлбэрт оруулах, сан үүсгэх;
- 6.4.2. Зорилтот бүлгийн хүн амын ойлголтын түвшинг судалж, мэдээллийн хэрэгцээг тодорхойлох;
- 6.4.3. Өдөр тутам цахим хуудас болон фейсбүүк хуудсыг шинэчлэх;
- 6.4.4. ШУН-ийн түвшинд ашиглагдаж буй программ хангамж, мэдээний санг хариуцан ажиллах;
- 6.4.5. Шаардлагатай үед ШУТ болон бусад ШУН-тэй хамтарсан инфографик, мэдээллийн хураангуй бэлтгэх;
- 6.4.6. ШУН-ийн цахим хуудас, фейсбүүк, жиргээ хуудсыг ажиллуулах;
- 6.4.7. Зоонозын халдварт өвчний эрсдлийн үеийн харилцаа холбооны үйл ажиллагааг халдвар хариуцсан багтай хамтран шуурхай зохион байгуулах;
- 6.4.8. Тэргүүлэх чиглэлд багтсан үйл явдлын талаар хүн амд зориулсан мэдээлэл, сурталчилгаа улиралчилал угтуулан ОНМХ-ээр хүргэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- 6.4.9. ОНМХ, цахим мэдээллийн эх сурвалжаас зоонозын шалтгаант үйл явдлын мэдээг түүвэрлэх, хянах;



6.4.10. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдалд хүргэх эрсдэл бүхий үйл явдлын талаарх түгээмэл асуулт, хариултыг халдвар хариуцсан мэргэжлийн багтай хамтран (frequently asked questions and answers) бэлтгэж, олон нийтэд мэдээлэх.

#### **6.5. Шуурхай удирдлагын багийн орон тооны бус гишүүд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

6.5.1. Шуурхай удирдлагын багийн орон тооны бус гишүүд нь Төвийн захирлын 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн А/18 дугаар тушаалаар батлагдсан мэргэжлийн багийн гишүүд байна.

6.5.2. ШУН идэвхжих үед тохиолдлын удирдлагын тогтолцооны багт ажиллах;

6.5.3. Зоонозын халдварт өвчний тандалт, эрсдлийн үнэлгээ, сургалт зохион байгуулах, нөөцийн бэлэн байдлыг хангах, эрсдлийн үеийн харилцаа холбоо, мэдээллийн технологи зэрэг үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдээр хариуцан ажиллах;

6.5.4. Тухайн хариуцсан зоонозын өвчний чиглэлээр олон жилийн тоон мэдээний дүн шинжилгээ, хандлага, хариу арга хэмжээний чиглэлийг тодорхойлох;

6.5.5. Өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай холбогдон тодруулга хийж, ШУН-ийн үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах;

6.5.6. Тухайн үйл явдалд түргэвчилсэн эрсдлийн үнэлгээ болон явцын, төгсгөлийн үнэлгээг хамтран гүйцэтгэх;

6.5.7. Төвийн мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн нь ШУН-ийн өрөөний тоног төхөөрөмжийн байнгын бэлэн байдал, засвар үйлчилгээг хангаж ажиллах.

### **Долоо. Үйл явдалд болон тохиолдолд суурилсан тандалтыг хэрэгжүүлэх**

#### **7.1. Тандалтын мэдээ ирүүлэх**

7.1.1 ШУН нь зоонозын халдварт өвчний үйл явдалд болон тохиолдолд суурилсан тандалтыг ЗӨСҮТ, орон нутгийн ЗӨСТ, ЭМГ-уудтай хамтран үндэсний хэмжээнд хэрэгжүүлэн ажиллана.

7.1.2 Аймаг нийслэлийн ЗӨСТ, ЭМГ-уудаас зоонозын халдварын хүний өвчний сэжигтэй тохиолдол (*тарваган тахал, боом, хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол, галзуу өвчний эрсдэлд өртсөн хүний тохиолдол, дэлхий дахинд бүртгэгдэж буй шинэ халдварт өвчний тохиолдол*) тухай бүр [eop@nczd.gov.mn](mailto:eop@nczd.gov.mn) цахим хаяг болон 11-70282853 дугаарын утсаар 24 цагийн турш ирүүлнэ.

7.1.3 Зоонозын халдварт өвчний үйл явдалд суурилсан тандалтын мэдээг аймаг, нийслэлийн ЭМГ, ЗӨСТ-өөс долоо хоног бүрийн Пүрэв гарагт [eop@nczd.gov.mn](mailto:eop@nczd.gov.mn) хаягаар мэдээлэх маягтын дагуу хүлээн авна. Тухайн орон нутагт ямар нэгэн үйл явдал бүртгэгдээгүй бол маягтад “0” тэмдэглэгээ хийж тогтмол мэдээ ирүүлнэ.

## **7.2. Мэдээг нягтлан баталгаажуулах:**

7.2.1. Зоонозын шалтгаант үйл явдлын албан бус мэдээг эрт илрүүлж, тухайн орон нутгийн эрүүл мэндийн газар болон Зоонозын өвчин судлалын төвөөс нягтлан баталгаажуулах ба халдвар хариуцсан багийн мэргэжилтнүүдээс ирүүлсэн тухайн аймгийн байгалийн голомт, өвчлөлийн суурь тоон мэдээнд харьцуулна.

## **7.3. Мэдээллийн давтамж, эргэн мэдээлэл**

7.3.1. Үйл явдалд суурилсан тандалт хариуцсан эмч нь Монгол Улсад бүртгэгдэж буй зоонозын халдварт өвчний албан болон албан бус мэдээг загварын дагуу бэлтгэж, өдөр бүр ЗӨСҮТ-ийн нийт ажилтнууд болон байгууллагын удирдлагуудад цахим хэлбэрээр тогтмол мэдээлнэ. Хэрэв тухайн өдөрт үйл явдал болон өвчний сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй бол мэдээлэл байхгүй талаар мэдээлнэ.

7.3.2. Дэлхий дахинд болон Монгол Улсад тохиолдож буй зоонозын өвчний үйл явдлын мэдээг нэгтгэж, дүн шинжилгээ хийн долоо хоног тутмын баасан гарагт ЭМЯ, ДЭМБ-ын Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газар, 21 аймгийн ЭМБ, мал эмнэлгийн байгууллага, ОБЕГ, МХЕГ зэрэг холбогдох байгууллагуудад цахим хэлбэрээр мэдээлж, байгууллагын цахим хуудсанд байршуулна. Долоо хоног тутмын мэдээнд зөвхөн тухайн долоо хоногт бүртгэгдсэн шинэ болон шинэчлэгдсэн мэдээг оруулна.

7.3.3. Тарваган тахал, боом, холер, шинэ сэргэж буй халдваруудын сэжигтэй, батлагдсан тохиолдлын мэдээг ЭМЯ-ны шуурхай удирдлагын албанд 2 цагийн дотор яаралтайгаар мэдээлнэ.

7.3.4. Бусад зоонозын халдварын үед өдөр тутмын мэдээ, долоо хоногийн эргэн мэдээллээр мэдээлэгдэнэ.

## **Найм. Эрсдлийн үнэлгээ хийж, гүйцэтгэх**

8.1. ШУН-д ирүүлж буй мэдээ, мэдээллийн үнэн бодитой баталгаат байдлыг ШУН-ийн багийн гишүүд хариуцна.

- 8.2. Эрсдлийн үнэлгээг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу гүйцэтгэж, үйл явдлын эрсдлийн зэргийг тогтоож, баталгаажуулна.
- 8.3. Бага эрсдэлтэй үед тайван цагийн горимоор ажиллана.
- 8.4. Дунд эрсдэлтэй үед халдвар хариуцсан мэргэжлийн баг ШУН-тэй хамтран удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу хамтарсан хариу арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 8.5. Эрсдлийн үнэлгээгээр өндөр, маш өндөр гэж үнэлэгдсэн тохиолдолд нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал гэж үзэх ба үнэлгээ хийснээс хойш ШУН-ийн зохицуулагч 30 минутын дотор төвийн захирал болон ШУН-ийн менежер мэдээлнэ.

### **Ес. Тохиолдлын удирдлагын тогтолцооны бүтэц, чиг үүрэг**

- 9.1. Зоонозын шалтгаант үйл явдлын хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд байгууллагын дотоод нөөц бололцоо хүрэлцэхээргүй болсон тохиолдолд Тохиолдлын удирдлагын тогтолцоо (ТУТ)-д шилжин ажиллана.
- 9.2. ТУТ-д шилжих шийдвэрийг ШУН-ийн менежер, мэргэжлийг багийн саналыг үндэслэн төвийн захирал гаргана.
- 9.3. ТУТ нь нь Төвийн захирлын 2016 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн А/42 дугаар тушаалаар батлагдсан Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүдүүвчээр томилогдож, тухайн тушаалаар заагдсан ажил үүргийг гүйцэтгэнэ.
- 9.4. **Тохиолдлын удирдлагын тогтолцоог цуцалсны дараах арга хэмжээ**
  - 9.4.1. Тохиолдлын удирдлагын тогтолцоог цуцалсан шийдвэрийг менежер багуудад мэдээлнэ;
  - 9.4.2. Шаардлагатай тохиолдолд цуцалснаас хойш 2 цаг дотор багтааж, хэвлэлийн бага хурал зарлан хуралдуулна;
  - 9.4.3. Баг бүр өөрийн үйл ажиллагааны тайлан, зөвлөмж болон санхүүгийн тайланг ажлын 5 хоногийн дотор багтаан бэлэн болгоно;
  - 9.4.4. Хариу арга хэмжээг үнэлэх үнэлгээний уулзалтыг зохион байгуулах;
  - 9.4.5. Багуудын үйл ажиллагаанаас гарсан зөвлөмжийг үндэслэн холбогдох тушаал, журам, заавар, стандартад болон энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт, тодотгол хийнэ;
  - 9.4.6. Хариу арга хэмжээний бичиг баримтуудыг баримтжуулж, архивлана.

### **Арав. Нөөцийн удирдлага, мэдээний сангийн баяжилт, ашиглалт**

- 10.1. ШУН нь мэдээллийг хүлээн авах тусгайлсан цахим шуудангийн хаяг, суурин утас, үүрэн холбооны ухаалаг утас, 24 цагийн интернеттэй байна.
- 10.2. ШУН-д зайлшгүй байх тоног төхөөрөмж, эд зүйлс, лавлагаа материалын жагсаалтыг төвийн захирлын тушаалаар баталгаажуулж, тус газрын үндсэн хөрөнгийн жагсаалтад бүртгэнэ.
- 10.3. Нөөц нь төвд хадгалагдаж буй бэлэн байдлын нөөцөөс бүрдэнэ.
- 10.4. Нөөцийн нэгдсэн бүртгэл, зарцуулалтыг хянах цахим мэдээллийн сантай байна.
- 10.5. Хамтарсан хариу арга хэмжээний үед нөөцөөс зарцуулах шаардлагатай тохиолдолд удирдлагын зөвлөлийн хурлаар зөвшилцөн шийдвэрлүүлнэ.
- 10.6. ШУН-д бүртгэгдсэн үйл явдлын мэдээг мэдээний сан хэлбэрээр хадгалагдана.
- 10.7. Мэдээний санг тогтмол баяжуулах үйл ажиллагааг асуудал хариуцсан мэргэжлийн багийн гишүүд хариуцна.
- 10.8. Төвийн мэдээлэл технологийн ажилтан нь ШУН-ийн тоног төхөөрөмж, интернет холболт, мэдээний сангийн байнгын ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хариуцаж ажиллана.
- 10.9. ШУН-ийн мэдээний сан нь байгууллагуудын төвийн өмч мөн.
- 10.10. Мэдээний санг эрдэм шинжилгээ, судалгаа, өгүүлэл, тандалтын зорилгоор мэргэжлийн багууд болон холбогдох мэргэжилтнүүд ашиглана. Хэрэв ганцаар ашиглах тохиолдолд асуудал хариуцсан мэргэжлийн багийн гишүүн удирдлагын зөвшөөрөл авна.

Төвийн захирлын 2016 оны  
10... дугаар сарын 06...ны өдрийн  
4/169 дугаар тушаалын II хавсралт





### ХҮСНЭГТ 1. ӨДӨР ТУТМЫН МЭДЭЭНИЙ МАЯГТ

#### 1. ШУН-ийн өдөр тутмын мэдээний маягт

2.	Үйл явдлын нэр*	
3.	Үйл явдлын товч	
4.	Үйл явдал мэдээлэгдсэн огноо	он ____ сар __ өдөр __ цаг __ мин __
5.	Мэдээ ирүүлсэн байгууллага	<input type="checkbox"/> ЭМГ <input type="checkbox"/> ЗӨСТ <input type="checkbox"/> ОБГ <input type="checkbox"/> МХГ <input type="checkbox"/> АНЭ <input type="checkbox"/> ХМХА <input type="checkbox"/> ХХААГ
6.	Эх сурвалжийн төрөл	<input type="checkbox"/> Албан <input type="checkbox"/> Албан бус <input type="checkbox"/> Иргэний мэдээлэл <input type="checkbox"/> Интернет мэдээлэл <input type="checkbox"/> ТВ, радио <input type="checkbox"/> Бусад
7.	Илрүүлсэн тандалтын хэлбэр	<input type="checkbox"/> Үйл явдалд суурилсан <input type="checkbox"/> Шалгуур үзүүлэлтэд суурилсан <input type="checkbox"/> Тохиолдолд суурилсан <input type="checkbox"/> Идэвхтэй
8.	Үйл явдал бүртгэгдсэн байршил	
9.	Үйл явдалд хүн өртсөн эсэх	<input type="checkbox"/> Тийм → Тоо _____ <input type="checkbox"/> Үгүй
10.	Үйл явдалд хүн нас барсан эсэх	<input type="checkbox"/> Тийм → Тоо _____ <input type="checkbox"/> Үгүй
11.	Лабораторийн шинжилгээнд сорьц авсан эсэх	<input type="checkbox"/> Тийм → Сорьцын төрөл _____ <input type="checkbox"/> Үгүй
12.	Лабораторийн шинжилгээний хариу	
13.	Үйл явдлын шалтгааны талаарх таамаглал	
14.	Эхний хариу арга хэмжээ (Мэргэжлийн байгууллагын хэрэгжүүлсэн)	
15.	Нэмэлт мэдээлэл	
16.	Мэдээлэл өгсөн ажилтны	Нэр _____ Албан тушаал _____ Гарын үсэг _____

\*Тайлбар: Үйл явдал бүртгэгдээгүй бол Үйл явдлын нэр хэсэгт "0" гэж бичиж ирүүлнэ

## ХҮСНЭГТ 2. ШУН-ИЙН ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭНИЙ МАЯГТ

Тэмдэглэгээ	Гол агуулга	Заавал оруулах мэдээлэл
	Шинэ бүртгэгдсэн үйл явдал	– Зоонозын шалтгаант тохиолдлын нэр, дэлгэрэнгүй мэдээлэл, тархвар судлалын холбогдол, лабораторийн шинжилгээ, сорьц цуглуулалт
	Хариу арга хэмжээ	– ЗӨСҮТ, ЗӨСТ, ЭМГ-аас хэрэгжүүлсэн арга хэмжээ, бусад байгууллагын оролцоо
	Үргэлжилж байгаа	– Орон нутгийн хэмжээнд бүртгэгдэж буй зоонозын халдварт өвчний дэгдэлтийн мэдээ
	Шинэчлэгдсэн мэдээ	– Шалгуур үзүүлэлтэд суурилсан тандалтаар мэдээлэгдэх өвчний 7 хоног тутмын шинэчлэгдсэн мэдээ

### ХҮСНЭГТ 3. ШУН-Д БУСАД ТАСГААС ХҮЛЭЭН АВАХ МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ, ДАВТАМЖ

№	Мэдээний төрөл	Давтамж
<b>Эрсдэлийн удирдлага бэлэн байдлын тасаг, Аймаг, нийслэлийн ЗӨСТ-өөс</b>		
1	<ul style="list-style-type: none"> <li>- Тарваган тахал өвчний сэжигтэй тохиолдол</li> <li>- Боом өвчний сэжигтэй тохиолдол</li> <li>- Галзуу өвчний сэжигтэй тохиолдол</li> <li>- Хачгаар дамжих халдварын нас баралт</li> <li>- Шалтгаан тодорхойгүй тохиолдлын нас баралт</li> <li>- Мал амьтны өвчлөл, үхлийн хэвийн бус байдал</li> <li>- Идэвхтэй тандалт судалгаагаар байгалийн голомтоос тарваган тахлын үүсгэгч илрүүлсэн тухай</li> <li>- Эрсдэлтэй объектоос боомын үүсгэгч илрүүлсэн тухай</li> <li>- Хайхардаггүй халдварт өвчний мэдээ</li> <li>- Шинэ ба сэргэн тархах халдварт өвчний мэдээ</li> </ul>	Мэдээлэл хүлээн авснаас хойш 24 цагийн дотор, түргэвчилсэн эрсдлийн үнэлгээний дүнгийн хамт
<b>Лавлагаа лабораторийн тасгаас</b>		
2	Зонхилон тохиолдох зоонозын шалтгаант хүний өвчний сэжигтэй тохиолдлын лабораторийн шинжилгээний үр дүн	Сорьц хүлээн авснаас хойш 24, 48 цагийн дараа
3	Зоонозын лабораторийн тандалтын нэгтгэсэн мэдээ	Сар бүр
<b>Ариутгал халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн тасгаас</b>		
4	Зоонозын шалтгаант халдварт өвчний сэжигтэй тохиолдлын дуудлагын үеийн ариутгал, халдваргүйтгэлийн мэдээ	Тухай бүр
<b>Бүх шатны эрүүл мэндийн байгууллагаас</b>		
5	Шинж тэмдэг тодорхойгүй нас баралтын 2, эмнэл зүйн ижил шинж тэмдэгтэй шалтгаан тодорхойгүй өвчний 3-аас дээш тохиолдол	Мэдээлэл хүлээн авснаас хойш 24 цагийн дотор, түргэвчилсэн эрсдлийн үнэлгээний дүнгийн хамт
6	Зоонозын халдварын сэжиг бүхий үйл явдлын мэдээ	Мэдээлэл хүлээн авснаас хойш 24 цагийн дотор, түргэвчилсэн эрсдлийн үнэлгээний дүнгийн хамт
<b>Мал эмнэлэг, үржлийн газраас</b>		
7	Шалтгаан тодорхойгүй мал олноор хорогдсон тухай мэдээ	Тухай бүр
8	Галзуу, боом, листериоз зэрэг өвчний сар, улирлын нэгтгэсэн мэдээ	Сар тутмын дараа сарын 10-ны дотор
<b>Онцгой байдлын ерөнхий газар</b>		
9	ОБЕГ-ын өдөр тутмын мэдээ	Өдөр бүр

**ХҮСНЭГТ 4. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР,  
ЗӨСТ-ӨӨС ИРҮҮЛЭХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭНИЙ МАЯГТ**

№	Үйл явдлын нэр	
1	Мэдээллийн эх үүсвэр	
2	Мэдээлсэн он, сар, өдөр	
3	Үйл явдал болсон газар	
4	Үйл явдал болсон хугацаа	
5	Үйл явдлын өртөлтийн мэдээлэл (хэдэн хүн өвчилсөн, нас барсан эсэх, өртсөн хүмүүсийн нас, нийгмийн байдал, мал амьтан өвчилсөн болон үхсэн эсэх)	
6	Нэмэлт мэдээлэл (эхэлсэн хугацаа, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, лабораторийн шинжилгээний дүн)	
7	Мэдээ өгсөн хүний нэр, албан тушаал, хаяг, утасны дугаар	


**ХҮСНЭГТ 5. ҮЙЛ ЯВДЛЫН ТАНДАЛТ УЦСАН ЭМЧИЙН МЭДЭЭ ЦУГЛУУЛАХ  
МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ**

Албан цахим хаяг, Монгол	Албан бус цахим хаяг, Олон Улс	Албан цахим хаяг, Олон Улс
<a href="http://www.moh.mn">www.moh.mn</a>	<a href="http://www.promedmail.org">www.promedmail.org</a>	<a href="http://www.who.int/csr/">www.who.int/csr/</a>
<a href="http://www.nccd.gov.mn">www.nccd.gov.mn</a>	<a href="http://www.cidrap.umn.edu">www.cidrap.umn.edu</a>	<a href="http://www.wpro.who.int/">www.wpro.who.int/</a>
<a href="http://www.flu.mn">www.flu.mn</a>	<a href="http://www.flutrackers.com">www.flutrackers.com</a>	<a href="http://www.web.oie.int">www.web.oie.int</a>
<a href="http://www.dvab.gov.mn">www.dvab.gov.mn</a>	<a href="http://www.birdflucorner.wordpress.com">www.birdflucorner.wordpress.com</a>	<a href="http://www.empresi.fao.org/empres-i/">www.empresi.fao.org/empres-i/</a>
<a href="http://www.scvl.gov.mn">www.scvl.gov.mn</a>	<a href="http://www.xinhuanet.com">www.xinhuanet.com</a>	<a href="http://www.oie.int">www.oie.int</a>
<a href="http://www.emchweb.mn">www.emchweb.mn</a>	<a href="http://www.news.google.com">www.news.google.com</a>	
<a href="http://www.emneleg.mn">www.emneleg.mn</a>	<a href="http://www.reuters.com/news/health">www.reuters.com/news/health</a>	
<a href="http://www.webdoctor.mn">www.webdoctor.mn</a>	<a href="http://www.bbc.co.uk/health/">www.bbc.co.uk/health/</a>	
<a href="http://www.euulmendinfo.mn">www.euulmendinfo.mn</a>	<a href="http://www.pandemicinformationnews.blogspot.com">www.pandemicinformationnews.blogspot.com</a>	
	<a href="http://www.news.yahoo.com/">www.news.yahoo.com/</a>	
	<a href="http://www.pubmed.com">www.pubmed.com</a>	



**ХҮСНЭГТ 6. ШУУРХАЙ УДИРДЛАГЫН НЭГЖИД БАЙХ  
ЛАВЛАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

<b>Мэдээллийн төрөл</b>	<b>Нарийвчилсан мэдээлэл</b>
<b>Үйл ажиллагаанд ашиглагдах тушаал, заавар</b>	Монгол Улсын стандартууд
	Сайдын тушаалаар батлагдсан заавар, журмууд
<b>Тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүн</b>	Зарлан дуудах схем
	Гэрийн хаяг, утас, яаралтай холбоо барих утас
<b>Зорчигч тээврийн мэдээлэл</b>	Онгоцны нислэгийн хуваарь, тариф
	Галт тэрэгний хуваарь, тариф
	Хот хоорондын зорчигч тээврийн хуваарь, тариф
<b>Газрын зураг</b>	Автозамын сүлжээний зураг
	Засаг захиргааны хуваарь бүхий газрын зураг
	Зонхилон тохиолдох нутагшмал зоонозын өвчний тархалтын зурагнууд
<b>Утасны лавлагаа</b>	Мэдээлэл солилцогч байгууллагуудын утасны лавлагаа
	Шар ном
	Төрийн байгууллагуудын утасны жагсаалт
	Цахим хуудасны хаягийн жагсаалт
<b>Нөөцийн мэдээлэл</b>	Хүн амын тоо (суурин хүн ам, насны бүлэг хүйсээр, сумаар)
	Халдварт өвчний дэгдэлтийн бэлэн байдлын нөөцийн жагсаалт
	Аймгийн төвүүд дэх зочид буудлын жагсаалт, тариф, холбоо барих утас
	Халдварт өвчний дэгдэлтийн хариу арга хэмжээний нөөцийн мэдээ
<b>Нууцлалын мэдээлэл</b>	Цахим хуудас, фейсбүүк, цахим шуудангийн хаягт нэвтрэх хэрэглэгчийн нэр, нууц үг


  
 Төвийн захирлын 2016 оны
   
 10 дугаар сарын 06 ны өдрийн
   
 А/69 дугаар тушаалын III хавсралт

**ТӨВИЙН ШУУРХАЙ УДИРДЛАГЫН НЭГЖИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

№	ШУН-ийн албан тушаал	Албан тушаал	Орлон ажиллах ажилтан	Гишүүнчлэлийн төрөл
1.	ШУН-ийн дарга	Төвийн захирал	Мэргэжлийн тусламжийн албаны дарга Тандалт хариуцсан тасгийн эрхлэгч	Орон тооны
2.	Менежер	Мэргэжлийн тусламжийн албаны дарга	Лавлагаа лабораторийн тасгийн эрхлэгч	Орон тооны
3.	Зохицуулагч	Тархвар судлагч эмч	Үйл явдалд суурилсан тандалт хариуцсан эмч	Орон тооны
4.	Үйл явдалд суурилсан тандалт хариуцсан эмч	Тархвар судлагч эмч	Тархвар судлагч эмч	Орон тооны
5.	Мэдээ, мэдээлэл, эрсдлийн үеийн харилцаа холбоо хариуцсан мэргэжилтэн	Хэвлэл мэдээлэл, маркетингийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Мэдээллийн технологийн ажилтан	Орон тооны

Төвийн захирлын 2016 оны  
 10 дугаар сарын 06 ны өдрийн  
 А/Б9 дугаар тушаалын IV хавсралт



**ЭРСДЛИЙН ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Зоонозын өвчин	ШУН-ийн зохицуулагч	Тархвар судлагч	Лабораторийн мэргэжилтэн	Эмнэл зүйч	Биологич
Тарваган тахал	Б.Амгаланбаяр	Д.Отгонбаяр	Д.Ганболд	Б.Дэлгэрмаа	Ц.Ганхуяг М.Байгалмаа
Боом		Э.Түвшинцэцэг	Б.Оргилбаяр		Б.Оюунбат Б.Болор С.Отгонжаргал
Галзуу		Б.Амгаланбаяр	Б.Байгалмаа		Ц.Баяр
Дамжуулагчаар дамжих халдвар		Б.Уянга Л.Роломжав	У.Өнөрсайхан		Б.Батцэцэг Л.Пүрэвдулам
Шалтгаан тодорхойгүй тохиолдол, үйл явдал		Б.Уянга Э.Түвшинцэцэг Ц.Отгонцэцэг	Д.Ганболд Н.Цэрэнбүжид		Ц.Ганхуяг, Б.Оюунбат
Шинэ болон сэргэн тархах халдварт өвчин	Шинэ сэргэн тархах зоонозын халдварт өвчин бүртгэгдсэн тохиолдолд тухайн үед төвийн захирлын шийдвэрээр баг томилогдож ажиллана.				